



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар ТУЗ2025-03/01

Улаанбаатар
хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.10, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ НЬ:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн 2024 оны тайлант санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, үндсэн үйл ажиллагаанаас ашигтай ажиллаагүй байгааг тус тус харгалзан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 2024 оны ажлын тайлан, ногдол ашиг хуваарилахгүй болсон тухай шийдвэр, шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Ц.Отгонбаяр), Ахлах нягтлан бодогч (Э.Оюунбилэг) нарт үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээллэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН